



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ БАНК

Хөгжил дэвшилд хамтдаа

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ (БОНЭМС) ГЭЖ ЮУ ВЭ?

ХХБанк нь Нидерландын хөгжлийн банктай хамтран 2012 оноос хойш БОНЭМС-ийг Монголдоо анх удаа нэвтрүүлсэн. Энэхүү системийн зорилго нь банк өөрсдийн болон харилцагчийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлаар явуулах, мөн зээлдэгчдийн үндсэн үйл ажиллагаа болон зээлийн зарцуулалтад эрсдэлийн үнэлгээ хийж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг нь бууруулах арга хэмжээг авахад оршино. Энэхүү систем нь банк болон зээлдэгчдийг байгаль орчин нийгмийн эрсдэл, зээлийн эрсдэл, нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

БОНЭМС-ийн үе шат

Зээлдэгчийн үйл ажиллагаа нь санхүүжүүлэхийг хориглосон жагсаалтад орсон эсэхийг шалгах

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийх. Шаардлагатай тохиолдолд нэмэлт нөхцөл тавина

Зээлийн гэрээ байгуулах. Нэмэлт нөхцлийг зээлийн гэрээнд тусгах

Банкнаас эргэн хяналт хийх, тавьсан нөхцлийн биелэлтийг хянана

“Хориотой үйл ажиллагааны жагсаалт” ХХБанк нь олон улсын хууль тогтоомж, конвенцоор хориглосон бизнесийн үйл ажиллагаануудыг багтаасан “Хориотой үйл ажиллагааны жагсаалт”-ыг мөрдөж ажилладаг бөгөөд уг жагсаалтад багтсан байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөтэй бизнесүүдийг санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримталдаг.

Бид хэрхэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийдэг вэ?



Зээлдэгчийн үйл ажиллагаатай биечлэн танилцана



Зээлдэгчээс үйл ажиллагаатай холбоотой материал ирүүлнэ



Нэмэлт судалгаан дээр үндэслэн анхан шатны болон нарийвчилсэн үнэлгээг хийдэг

ХХБАНКНЫ “ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН КОДЧИЛОЛ”

Бид таны бизнесийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэхдээ “Эдийн засгийн салбарын кодчилол”-ын дагуу 322 дэд салбарт ангилан гэрлэн дохионы загвараар анхан шатны болон нарийвчилсан үнэлгээг хийдэг.

Ногоон – Бага эрсдэлтэй *		Анхан шатны үнэлгээ
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт		
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ		
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа		
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал		
Боловсрол		
Хүний эрүүл мэнд болон нийгмийн халамжийн үйл ажиллагаа		
Урлаг, үзвэр, тоглоом наадам		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа		
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		
Шар – Дундаж эрсдэлтэй		Нарийвчилсан үнэлгээ
Боловсруулах үйлдвэрлэл		
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		
Улаан – Өндөр эрсдэлтэй		
Уул уурхай, олборлолт		
Барилга		
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		

* Эдийн засгийн дэд салбаруудаас хамааран шар, улаан ангилалд орж болно.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ЮУГ АНХААРДАГ ВЭ?

Бид Олон улсын санхүүгийн корпораци (IFC performance standards) –аас гаргасан гүйцэтгэлийн 8-н стандартын дагуу таны байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг (Due diligence) хийдэг.



PS 1: Нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага



PS 2: Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл



PS3: Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос урьдчилан сэргийлэх нь



PS 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал



PS 5: Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт



PS 6: Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага



PS 7: Нутгийн уугуул иргэд



PS 8: Соёлын өв

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭМЭЛТ НӨХЦӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ нь банкны зүгээс таны бизнесийн үндсэн үйл ажиллагаа болон зээлийн зарцуулалтад үнэлгээ хийсний үр дүнд байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс банкнаас зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд, тусгаж буй нэмэлт үүрэг юм.

Жишээлбэл:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх
- ХАБЭА-н журам боловсруулан дагаж мөрдөх
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан биелүүлж ажиллах.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж ажиллах гэх мэт.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗӨРИЛГО

1 ядуурлыг устгах



2 өлсгөлөнг зогсоох



3 эрүүл мэндийг дэмжих



4 чанартай боловсролыг дэмжих



5 жендерийн эрх тэгш байдлыг хангах



6 баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах



7 сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх



8 зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих



9 инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх



10 тэгш бус байдлыг бууруулах



11 ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих



12 хариуцлагатай хэрэглээг дэмжих



13 уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах



14 далай тэнгисийн нөөцийг хамгаалах



15 хуурай газрын эко системийг хамгаалах



16 энх тайван, шударга ёсыг цогцлоох



17 хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn

